



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.2, 3.3, 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн 2020 оны төсөв батлах тухай” 19 дүгээр тогтоолын дагуу тус сургуулийн албан хэрэгцээнд зориулан, өөрийн хөрөнгийн болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр 13,224,166,690.00 (арван гурван тэрбум хоёр зуун хорин дөрвөн сая нэг зуун жаран зургаан мянга зургаан зуун ерэн) төгрөгт багтаан хавсралтад заасан төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, үндсэн хөрөнгө олж авахыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэн, Монгол Улсын Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ж.Цолмон нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



З.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 02 дугаар сарын 11-ний
өдрийн 20 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН
2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/д	Төсөл арга хэмжээний нэр төрөл, хүчин чадал	Байршил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Төсөвт өртөг
					(мян.төгрөг)
	1. Барилга, их засвар				12,677,709.09
1	АШУУИС-ийн Сургалтын, цогцолборын 1200 оюутны байрны барилга угсралтын нэмэлт ажил	АШУУИС-ийн төв	м.кв	12138	727,201.30
2	Спорт цогцолбор барилга угсралтын ажил	АШУУИС-ийн төв	м.кв	5646	1,634,317.91
3	Номын сангийн барилга угсралтын ажил	АШУУИС-ийн төв	м.кв	2952	2,512,858.18
4	Соёлын төвийн барилга угсралтын ажил /цогцолборын/	АШУУИС-ийн төв	м.кв	4696	5,067,256.00
5	Номын сан, Соёлын төв, Спорт төвийн гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралт	АШУУИС-ийн төв	багц	1	28,220.00
6	С, D, E, F блокын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажил	АШУУИС-ийн төв	багц	1	735,000.00
7	А, Б блокийн гадна замын ажил	АШУУИС-ийн төв	м.кв	950	52,077.70
8	С, D, E, F блокын гадна зам талбай, тохижилт, гадна гэрэлтүүлэг, ногоон байгууламжийн ажил	АШУУИС-ийн төв	м.кв	5000	269,062.40
9	Хонгор суманд байрлах эмийн ургамлын полигоны газарт цахилгааны шугам татах ажил	Дархан-Уул аймаг дахь салбар АУС	м	150	15,000.00
10	Хонгор суманд байрлах эмийн ургамлын полигонд гүний худаг гаргах ажил	Дархан-Уул аймаг дахь салбар АУС	м	80-100	13,500.00
11	Гүний худаг гаргах	Дорноговь аймаг дахь салбар АУС	м	50-100	20,000.00
12	Эрхэс сувилалын өвлийн байр	АШУУИС-ийн төв	м.кв	3000	1,200,000.00
13	Баянчандмань дахь сувилалд байшин барих	АШУУИС-ийн төв /ИСНЭ/	м.кв	130	80,000.00
14	Лицей сургуулийн гадна тохижилт, их засвар	АШУУИС-ийн төв	багц	1	150,000.00

15	Хичээлийн А байрны гадна фасад	Дархан-Уул аймаг дахь салбар АУС	м.кв	2347,3	100,000.00
16	Спорт заалны дээврийн их засвар	Дархан-Уул аймаг дахь салбар АУС	м.кв	540	25,000.00
17	Их сургуулийн нэгдсэн эмнэлгийн дотор их засвар	АШУУИС-ийн төв /ИСНЭ/	багц	1	19,215.60
18	Сургалтын өрөө засварлах	АШУУИС-ийн төв /БАС/	багц	1	19,000.00
19	Хичээлийн шинэ байрны зураг	Дорноговь аймаг дахь салбар АУС	ш	1	10,000.00
2. Тоног төхөөрөмж					
20	Үзлэгийн тоног төхөөрөмж	АШУУИС-ийн төв /ИСНЭ/	багц	1	6,998.30
21	Физикийн лабораторийн тоног төхөөрөмж	АШУУИС-ийн төв /БАС/	багц	1	13,954.90
22	Гистологийн лабораторийн тоног төхөөрөмж	АШУУИС-ийн төв /БАС/	багц	1	36,472.90
23	Эм судлалын лабораторийн тоног төхөөрөмж	АШУУИС-ийн төв /БАС/	багц	1	40,080.00
24	Лабораторийн тоног төхөөрөмж	АШУУИС-ийн төв /НЭМС/	багц	1	53,200.00
25	Лабораторийн тоног төхөөрөмж	АШУУИС-ийн төв /АУС/	багц	1	100,000.00
26	Оффсет хэвлэх машин	АШУУИС-ийн төв /хэвлэх үйлдвэр/	ш	1	250,000.00
3. Автомашин					45,751.50
27	Автомашин (суудлын тоо-10, хөдөлгүүрийн багтаамж 3000 cc хүртэл) шинэ	Говь-Алтай аймаг дахь салбар АУС	ш	1	45,751.50
Барилга, их засварын дүн				19	12,677,709.09
Тоног төхөөрөмжийн дүн				7	500,706.10
Автомашины дүн				1	45,751.50
					13,224,166.69
Нийт дүн				27	(арван гурван тэрбум хоёр зуун хорин дөрвөн сая нэг зуун жаран зургаан мянга зургаан зуун ерэн)